

Маягт СЗХ04008

Даатгалын бүтээгдэхүүний мэдэгдлийн маягт

1	Мэдэгдэл огноо	Он	2021	Сар	03	Өдөр	31	
2	Мэдэгдэл гаргагчийн оноосон нэр	БОДЬ ДААТГАЛ ХК						
3	Даатгалын бүтээгдэхүүний нэр	ГАДААД АЧАА ТЭЭВРИЙН ДААТГАЛ						
4	Даатгалын бүтээгдэхүүний холбогдох даатгалын хэлбэр	Ачааны даатгал						
5	Даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	Шийдвэрийн нэр		Огноо		Дугаар		
		Даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах тухай		2021.03.31		ТУЗ/2107		
6	Цахимаар борлуулах эсэх	<input type="checkbox"/> Тийм <input checked="" type="checkbox"/> Үгүй						
7	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Овог		Нэр				
		Балсан		Баярмагнай				
Мэдээллийн төрлийг сонгоно уу.								
8	Даатгалын бүтээгдэхүүнийг шинээр борлуулах <input checked="" type="checkbox"/> Даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэх							
Даатгалын бүтээгдэхүүний ерөнхий мэдээлэл								
9	Даатгалын зүйл	Даатгуулагчийн эзэмшил, өмчлөл эсвэл хариуцлагад байгаа олон улсад тээвэрлэгдэж байгаа ачаа бараа						
	Даатгалын үндсэн эрсдэл	Даатгалын эрсдэл				А	В	С
	1	Гал түймэр, дэлбэрэлт;					+	+
	2	Газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, аянга цахилгаан,					+	+
	3	Тээврийн хэрэгсэл хөмрөх, онхолдох, төмөр замаас гарах					+	+
	4	Тээврийн хэрэгсэл хоорондоо эсвэл үл хөдлөх биет, хөвөгч юмсыг мөргөж цохих, гүүрийн нуралт;					+	+
	5	Аюул учирсан үед ачааг портоос шилжүүлэх явцад гарах хохирол;				БҮХ ЭРСДЭЛ /Гэрээний хасалт хэсэгт зааснаас бусад/	+	+
	6	Хөлөг онгоц усанд живэх, шидэгдэх, хөлөг онгоц болон нисдэг тэрэг сураггүй алга болох;					+	+
	7	Ерөнхий дундаж / General Average					+	-
	8	Ачааг хаях / Jettison					+	-
	9	Хөлөг онгоц, чингэлэг, галт тэрэг, агуулахад далай, нуур, голын ус нэвтрэн орох;					+	-
10	Ачааг ачиж буулгах болон тээврийн хэрэгсэл дээр байх үеийн аливаа бүрэн сүйрэл болон алга болох эрсдэл				+		-	

Даатгалын нэмэлт эрсдэл	-
Даатгалын хураамжийн хувь, хэмжээ	Үндсэн эрсдэл: 0,02-6,0%,

ДААТГАЛД ХАМРАГДАХГҮЙ НӨХЦӨЛ

1. Барааны ердийн элэгдэл хорогдол, ууршилт, гадны нөлөөгүй өөрчлөлтүүд;
2. Шаардлага хангаагүй сав (вагон, контейнер болон барааг агуулж байгаа бусад бүх төрлийн), техникийн шаардлага хангаагүй тээврийн хэрэгслээр тээвэрлэснээс, бэхэлгээ хийгээгүй, бэхэлгээг дутуу, стандартын бус хийснээс болж учирсан хохирол;
3. Ачаа барааны өөрийнх нь шинж чанараас шалтгаалж гарсан хохирлууд, ялангуяа хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүнд тээвэрлэлтийн явцад гарсан чанарын өөрчлөлтүүдээс шалтгаалсан хохирлууд;
4. Энэхүү гэрээний 11.4.12 -д заасан гол өөрчлөлтүүдийн талаар цаг тухайд нь мэдээлээгүй бол мөн ачаа барааг тусад нь хадгалж байх үеийн эрсдлээс учирсан хохирол;
5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан тээвэрлэлтийн маршрут зөрчсөнөөс гарсан хохирол;
6. Учирсан хохирлын хэмжээ, шалтгааныг тогтооход чухал нөлөө бүхий хүчин зүйлсийг буруу мэдээлэх, хууран мэхлэх, нуун дарагдуулсан бол;
7. Даатгуулагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас хохирол бий болсон;
8. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хохирлын нэхэмжлэлийг даатгалын тохиолдол болсон өдрөөс хойш хуанлийн 180 хоногийн дотор даатгагчид гаргаагүй бол;
9. Даатгуулагчийн хууль бус, санаатай, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн үр дагавар;
10. Учирсан хохирлоос үүдэн гарсан сэтгэл санааны хохирол, олох ёстой байсан орлого болон бусад үр дагавар, үйлчлүүлэгчийн өмнө хүлээх тээвэрлэлтийн гэрээний дагуу хүлээх хариуцлагаас үүдсэн торгууль, алданги;
11. Сав баглаа, боодолд учирсан хохирол;
12. Торгууль, шийтгэвэр, хүү, авлага, гаалийн зардал, бүрдүүлэлттэй холбоотой аливаа зардал;
13. Ачаа барааг монгол улсын эсвэл дамжин өнгөрүүлэх, тээвэрлэх улс орнуудын хуулинд заасан журам нөхцөлийн дагуу хураасан, устгасан;
14. Гэрээнд заасан эрсдлээс бусад шалтгаанаар замд саатсаны улмаас үүссэн хохирлууд;
15. Амьд амьтан, тамхи, бэлэн мөнгөний тээвэрлэлт, үлдэгдэл өртгийн даатгал. /хөрөнгийн үнэ цэнэ буурах эрсдэлийг ойлгоно/ үр дагаврын даатгалын гэрээгээр төлөгдөх хохирол. /хохирлоос үүдсэн алдагдсан боломж, ажил хойшлох эрсдэл, эдийн засгийн хохирол, олох байсан ашиг/;
16. Даатгуулсан материалын цөмийн хайлш болон задралаас үүдэлтэй цөмийн материалын алдагдал, хохирол эсвэл зардлын хамгаалалтын даатгал;
17. Дайны эрсдлээс хөлөг онгоц, агаарын хөлөг сүйрснээс үүдсэн хохирол, тухайн бүсийг “held covered” хэмээн зарлагдахаас өмнө хамруулсан дайны даатгалаас бусад нөхцөлд, Лондоны биржийн холбогдох байгууллагын дагуу “held covered” хэмээн зарласан бүсэд нэвтрэх, бүсээс гадна эсвэл бүс доторх аялал, дайны нислэгийн хамгаалалтын даатгал (“held covered” гэж зарлагдсан орон, газар, газрын боомтын бүс, нисэх онгоцны буудал хамрагдана);
18. Гуравдагч этгээд учирсан хохирлыг даатгуулагчид төлж барагдуулсан, даатгуулагч нь гуравдагч этгээдэд шаардлага гаргах эрхээсээ татгалзсан бол тус хэмжээгээр;
19. Даатгалын тохиолдолд буруутай гуравдагч этгээд тодорхой байх үед даатгуулагчийн өөрийн алдаа, хайхрамжгүй үйлдэл, эс үйлдлээс даатгалын хохирлыг буруутай этгээдээс нэхэмжлэх боломжгүй болгосон тохиолдолд нөхөн төлбөр олгогдохгүй;
20. Олон улсын ачаа тээврийн нэгдсэн хороо (Joint Cargo Committee / JCC) –с зарладаг жагсаалтанд байгаа улсуудаас “Very High” буюу өндөр зэрэглэлийн эрсдэлтэй гэж тусгагдсан улс орнуудыг дамжин өнгөрөхөд учирсан хохирол болон тус бүс нутаг улс орнууд уруу тээвэрлэсэн болон тэндээс тээвэрлэсэн ачаа бараа <http://watch.exclusive-analysis.com/jccwatchlist.html>;
21. Дайн, дайн бүхий байдал, зэвсэгт бослого, байлдааны зэвсэг хэрэглэх, үймээн самуун, террорист үйл ажиллагаа, ажил хаялт, нийгмийн эмх замбараагүй байдал, бослого, төрийн захиргааны байгууллагын акт шийдвэр, цацраг идэвхит бодис буюу туяаны хордлого, цөмийн дэлбэрэлт, улс төрийн тэмцэл, ой хээрийн түймэр, гамшгийн үед учирсан хохирол зэргийн улмаас үүссэн нөхцөл байдал, хохирол, цөмийн хайлш болон задралаас үүдэлтэй цөмийн материалын алдагдал, хохирол эсвэл зардлын хамгаалалтын даатгал;
22. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх тухай хуульд заасны дагуу мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой бараа бүтээгдэхүүн тээвэрлэсэн тохиолдолд нөхөн төлбөр олгохгүй;

23. Хууль тогтоомжинд заасан бусад үндэслэл.